

Төсөл
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн
сайдын 20... оны ... сарын . . .-ны өдрийн
..... дугаар тушаалын хавсралт

Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих, үр дүнг мэдээлэх журам

Нэг. Нийтлэг үндэслэл

Мал эмнэлгийн үйлчилгээг холбогдох хууль, тогтоомж, стандарт, дүрэм, журам, заавар, норм, нормативыг мөрдөн, чанарын өндөр түвшинд хүртээмжтэй хүргэх, мал эмнэлгийн үйл ажиллагааны өдөр тутмын хяналтыг сайжруулахад энэхүү журмын зорилго оршино.

1.1. Энэхүү журмыг сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулах эрх бүхий мал эмнэлгийн үйлчилгээний нэгж, түүний малын эмч, бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын /ахлах/ байцаагч дагаж мөрдөнө.

1.2. Журмаар Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.18, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт заасан харилцааг зохицуулна.

Хоёр. Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавих

2. Сум, дүүрэг дэх мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч мал эмнэлгийн үйлчилгээнд өдөр тутмын үйл ажиллагааны хяналтыг дараахь чиглэлээр тавина.

2.1. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн ажлын байрны стандартын хэрэгжилтийг хангуулах **өдөр тутмын** хяналт хэрэгжүүлнэ.

2.1.1. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн стандартын хэрэгжилтийг хангуулах зорилгоор батлагдсан шалгуур үзүүлэлтээр ажлын байр, шаардлагатай багаж, тоног төхөөрөмжийн хангалт, бэлэн байдалд жилд нэг удаа үнэлгээ өгнө.

2.1.2. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээний дагуу ажлын байр, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулна.

2.1.3. Ажлын байр, багаж тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж чадахгүй, хугацаатай үүрэг даалгаврыг 2 ба түүнээс дээш удаа биелүүлээгүй мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээт цуцлуулах саналыг сум, дүүргийн Засаг дарга, аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газарт гаргаж шийдвэрлүүлнэ.

2.2. Мал, амьтны халдварт, шимэгчтэх, халдваргүй өвчнөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх, эмчлэх арга хэмжээний технологи, үйл ажиллагаанд өдөр тутмын хяналт хэрэгжүүлнэ.

2.2.1. Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээний гүйцэтгэлийг гэрээт өрхүүдийн малын эрүүл мэндийн дэвтэрийн бүртгэл, цахим системийн бүртгэлтэй харьцуулан улирал тутамд үнэлгээ өгч гаргана.

2.2.2. Мал, амьтны халдварт, шимэгчтэх, халдваргүй өвчнөөс ерөнхий урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч, үзлэг тандалт хийсэн ажлын үр дүнг өрхүүдийн малын эрүүл мэндийн дэвтэрийн бүртгэл, цахим системийн бүртгэлтэй харьцуулан улирал тутамд үнэлгээ өгнө.

2.2.3. Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөт арга хэмжээний эм, биобэлдмэлийн зарцуулалтад захиалга, өрхүүдийн малын эрүүл мэндийн дэвтэрийн бүртгэл, цахим системын бүртгэл, тарилга, туулгалтын цуваа, үйлчилгээ үзүүлдэг гэрээт өрхийн албан ёсны бүртгэл дэх малын тоо зэрэгтэй харьцуулан улирал тутамд үнэлгээ өгнө.

2.2.4. Мал, амьтны халдварт өвчний тархалтыг тогтоох тандалтын дээж цуглуулах, шинжилгээ хийх үйл ажиллагаанд батлагдсан удирдамж, зааврын дагуу гүйцэтгэж байгаа эсэх, стандарт ажиллагааны зааварыг мөрдөж байгаа байдалд улирал тутамд үнэлгээ өгнө.

2.2.5. Мал, амьтны халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилга, туулгалт, тандалтын шинжилгээний дээж цуглуулах, сүргийн эрүүл мэндийн үзлэг хийх үйл ажиллагаанд явцад стандарт ажиллагааны зааварын хэрэгжилтэд улирал тутамд үнэлгээ өгнө.

2.2.6. Мал, амьтны өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх талаар сал эмнэлгийн үйлчилгээний нэгж, түүний малын эмчийн гэрээт өрхүүдэд зөвлөмж, мэдээлэл хүргэсэн байдал, түүний үр дүнд улирал тутамд үнэлгээ өгнө.

2.2.7. Хариуцсан гэрээт нутаг дэвсгэрт зүйн бусаар хорогдсон мал, амьтны сэг зэмийг устгах ажлыг зохион байгуулсан, хашаа, хороо, өтөг бууцанд халдваргүйтгэл хийн ажлын гүйцэтгэлийг үйлчилгээ үзүүлсэн өрхийн эрүүл мэндийн дэвтэрийн бүртгэл, халдваргүйтгэлийн бэлдмэлийн захиалга, зарцуулалтын тайлантай харьцуулан улирал тутамд үнэлгээ өгнө.

2.2.8. Мал, амьтны эмийн зохистой хэрэглээг хэвшүүлэх зорилгоор мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн хэрэглэсэн, зарцуулсан эмийг зарцуулалтын тайлан, орлогын тайланд улирал тутамд үнэлгээ өгнө.

2.2.9. Мал, амьтны гоц халдварт өвчний сэжиг илэрсэн, оношлогдсон үед батлагдсан журам, заавар, стандарт ажиллагааны зааврын мөрдөлтөд тухай бүрт нь хяналт тавина.

2.3. Мал, амьтны шилжилт хөдөлгөөнөөр дамжин тархах халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал, амьтны гаралтай түүхий эд бүтээгдэхүүний ариун цэвэр, аюулгүй байдлын баталгаажуулалтын байдалд өдөр тутмын хяналт хэрэгжүүлнэ.

2.3.1. Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хариуцсан нутаг дэвсгэрт өөр нутаг дэвсгэрээс шинжиж ирсэн, шилжин явсан малын бүртгэл хөтлөлтийг гэрээт өрхийн малын албан ёсны бүртгэл, мал эмнэлгийн эрүүл мэндийн тодорхойлолт олголттой харьцуулан халдварт өвчин дамжин тархах эрсдэл үүссэн эсэхэд улирал тутамд үнэлгээ өгнө.

2.3.2. Халдварт, зoonоз өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал, амьтны гаралтай бүтээгдэхүүний аюулгүй байдлыг баталгаажуулах мал эмнэлгийн эрүүл мэндийн тодорхойлолт олгох үйл явцыг цахим мэдээлийн сангийн бүртгэл, малчин өрхийн зах зээлд борлуулалттай улирал тутамд үнэлгээ өгнө.

Гурав. Хяналт шалгалтын дүнг тайлагнах, мэдээлэх

3.1. Сум, дүүргийн мал эмнэлгийн байцаагч мал эмнэлгийн үйлчилгээнд үйл ажиллагааны хяналт хийсэн тайланг батлагдсан маягтын дагуу улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор цахим хэлбэрээр аймаг, нийслэл дэх Мал эмнэлгийн газрын асуудал хариуцсан мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагчид илгээнэ.

3.2. Аймаг, нийслэл дэх Мал эмнэлгийн газрын асуудал хариуцсан мал эмнэлгийн хяналтын улсын ахлах байцаагч сумдаар ирүүлсэн цахим тайланг нэгтгэн улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн хяналт, эрсэдлийн үнэлгээний газарт цахим хэлбэрээр илүүлнэ.

3.3. Мал эмнэлгийн үйлчилгээнд хяналт тавьсан тайланг цахим системд нэвтрүүлсэн болсон цахим системээр мэдээ, тайлан илгээх журамд зааснаар зохицуулна.

Дөрөв. Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэгчийн эрх, үүрэг

4.1. Мал эмнэлгийн үйлчилгээнд тавьж буй үйл ажиллагааны хяналт, шалгалттай холбоотой гомдолоо мал эмнэлгийн удирдах дээд байгууллага, албан тушаалтанд гаргах эрхтэй.

4.2. Мал эмнэлгийн үйлчилгээ эрхлэх үйл ажиллагааг зогсоосон болон бусад хэлбэрээр гаргасан мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэргийн шүүхэд хандах эрхтэй.

4.3. Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа гэрээт мал эмнэлгийн нэгж энэхүү журмын 2 дахь хэсэгт заасан ажил үйлчилгээний гүйцэтгэлийг цахим мэдээллийн санд тухай бүрт нь оруулна.

4.4. Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналт хэрэгжүүлэх эрх бүхий мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагааны хяналт хийхтэй холбогдуулан шаардсан мэдээ, тайлан, бичиг баримтыг тухай бүрт нь гаргаж өгнө.

4.5. Мал эмнэлгий үйл ажиллагааны хяналт хэрэгжүүлэх эрх бүхий мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй

Тав. Мал эмнэлгийн байгууллагын эрх, үүрэг

5.1. Мал эмнэлгийн ерөнхий газар дараахь чиг үүрэгтэй. Үүнд:

5.1.1. Мал эмнэлгийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын үр дүнг нэгтгэн дүгнэж мал эмнэлгийн ажил үйлчилгээг хүртээмжтэй, үр дүнтэй болгох талаар бодлого боловсруулж хэрэгжүүлэх,

5.1.2. Мал эмнэлгийн үйлчилгээний чанарыг сайжруулах, бэлэн байдлын чадавхийг сайжруулах талаар хуулиар олгогдсон бүрэн эрхийн хэрүүэнд бүхий арга хэмжээ авах,

5.1.3. Мал эмнэлгийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын үр дүнгээр хуулиар хүлээсэн үүргээ хамгийн сайн гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн шалгаруулж хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд урамшуулах,

5.2. Аймаг, нийслэл дэх Мал эмнэлгий газар дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.2.1. Мал эмнэлгийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын үр дүнгээр хуулиар хүлээсэн үүргээ хамгийн сайн гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн шалгаруулж урамшуулахаар нэр дэвшүүлэх,

5.2.2. Мал эмнэлгийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын үр дүнгээр хуулиар хүлээсэн үүргээ хамгийн хангалтгүй гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээг цуцалж, малын эмчийн итгэмжлэлийг цуцлах, түдгэлзүүлэх, ёс зүйн хариуцлага хүлээлгэх саналаа Малын эмчийн итгэмжлэл олгох зөвлөлд хүргүүлэх,

5.2.3. Мал эмнэлгийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын үр дүн, сум, дүүрэг дэх Мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн санал, дүгнэлтийг үндэслэн хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид улсын төсвөөс олгох ажил үйлчилгээний хөлсийг хасах,

5.3. Сум, дүүрэг дэх Мал эмнэлгийн тасаг дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

5.3.1. Энэхүү журмын 2 дахь хэсэгт заасан ажил, үйлчилгээний төлөвлөлтийн тухай бүрт нь цахим мэдээллийн системд оруулах,

5.3.2. Мал эмнэлгийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын үр дүнгээр хуулиар хүлээсэн үүргээ хамгийн сайн гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн шалгаруулж урамшуулахаар нэр дэвшүүлэх,

5.3.3. Мал эмнэлгийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын үр дүнгээр хуулиар хүлээсэн үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжид улсын төсвөөс олгох ажил үйлчилгээний хөлсийг хасах санал, дүгнэлт гаргах,

5.3.4. Мал эмнэлгийн үйлчилгээнд хийсэн хяналт шалгалтын үр дүнгээр хуулиар хүлээсэн үүргээ хамгийн хангалтгүй гүйцэтгэсэн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн гэрээг цуцалж, малын эмчийн итгэмжлэлийг цуцлах, түдгэлзүүлэх, ёс зүйн хариуцлага хүлээлгэх дүгнэлт гаргах,

5.4. Мал эмнэлгийн үйл ажиллагааны хяналт хэрэгжүүлэх эрх бүхий улсын байцаагч нь Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.13-17, 30.22-23, 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэрэгт заасан хяналтыг хэрэгжүүлнэ.

Зургаа. Хариуцлага

6.1. Энэхүү журмын хэрэгжилтэд бүх шатны мал эмнэлгийн хяналтын улсын байцаагч хяналт тавьж журмыг зөрчсөн этгээдэд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу шийтгэл ногдуулна.